БАТЛАВ
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ӨЛЗИЙ
2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр

0.31 КМ АВТО ЗАМЫН АЖИЛ (БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 16 ДУГААР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Улаанбаатар хот

1.	Ажлын зорилго үндэслэл	- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; - 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг; - Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл; - Баянзүрх дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр; - Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”; - “Баянзүрх дүүргийн хөгжлийн зураглал-2030” дунд хугацааны бодлогын баримт бичиг; - Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 8 дугаар сарын 26-ны өдрийн 48 дугаар тогтоол;
2.	Байршил, Зориулалт хүчин чадал	- Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо, 0.31 км авто замын ажил;
3.	Архитектур төлөвлөлтийн объектын бүрэлдэхүүн шаардлага, зориулалт, хүчин чадал	- Авто зам: 3.5 метрээс багагүй өргөнтэй, 2 эгнээ байх (7.0 метрээс багагүй байх); - Явган хүний зам: Өргөн 1.5 метрээс багагүй байх; - Дугуйн зам: Өргөн 2.0 метрээс багагүй байх: - Гэрэлтүүлэг: 30 метр тутамд 9-12 метрийн өндөртэй шон, 150 Вт чадалтай чийдэн байх; - Тэмдэг тэмдэглэгээ: Явган болон автомашинаар зорчигчдын аюулгүй байдлыг хангасан тэмдэг тэмдэглэгээ хийгдсэн байх;
4.	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	- Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт;
5.	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	- Нийслэлийн авто зам, Нутаг дэвсгэрийн туслах гудамж зам;
6.	Замын хучилтын хийц	- Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэх; - Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын техникийн нөхцөлийг хангаж автомашин, явган хүний хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг хангах зорилгоор барих;

7.	Зураг төслийн иж бүрдэл	- Инженер геодезийн ажлын тайлан; - Инженер геологийн судалгааны ажлын тайлан; - Авто зам, замын байгууламжийн ажлын инженерийн нарийвчилсан зураг төсөл; - Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ус зүйн тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто зам, замын байгууламжийн зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж, техникийн нөхцөл, магадлалын дүгнэлт гэх мэт); - Техникийн шаардлага; - Холбогдох шугам сүлжээний зураг төсөл, төсөв; - Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв; - Төслийн танилцуулга;
8.	Эдийн засгийн тооцоо төсөв.	- Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн бусад программаар тооцох;
9.	Тавигдах шаардлага	- Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай зөвшилцөх ба Хот байгуулалт, Хөгжлийн газар болон Нийслэлийн замын хөгжлийн газрын даалгаврууудын шаардлагуудыг хангаж ажиллах;

ХЯНАСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХАШ-ЭРДЭНЭ

БОЛОВСРУУЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Л.БАТБАЯР

ТӨЛӨВЛӨЖ БУЙ АВТО ЗАМЫН ХАВСРАЛТ

ТАНИХ ТЭМДЭГ

Төлөвлөж буй авто зам